

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 11 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.11.20

Газрын төлбөрийн орлого:

Газрын төлбөрийн тайланг цахимаар гаргадаг болсонтой холбогдуулан мэдээллийн сантай тулгалт хийж цахимаар тайлан гаргахад мэдээллийг бэлтгэж ажилласан бөгөөд 317 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 93.730.071 сая төгрөгийн бүртгэлийг тайланд шивж оруулахад бэлтгэсэн.


➤ 269 иргэний 3.652.430 сая төгрөг

➤ 48 аж ахуйн нэгж, байгууллагын 90.077.641 сая төгрөгийн мэдээллийг нэгбүрчлэн нэр, регистрээр гаргаж тулгалт хийлээ.

2017 оны газрын төлбөрийн биелэлт 93'730'071 төгрөг буюу 104.1%-тай байна.

Газар эзэмшигч 46 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 58 нэгж талбарын газар эзэмших, ашиглах гэрээг дүгнэсэн.

Газар зохион байгуулалтын 2018 оны тухайн жилийн төлөвлөгөөнд санал авах тухай зарыг аймгийн залуус телевизээр явуулж, мөн байгууллагын вэб сайт болон facebook хаягаар зарласан.



Шивээговь сумын иргэн нэхэмжлэгч Ч.Гомбо, хариуцагч Ш. Бадамханд нарын гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 820 м² газрын давхцалтай гэсэн маргааныг газар дээр нь хэмжилт хийж шинжээчийн дүгнэлтийг **Шүүхийн ЗДТГазарт** 11 сарын 01-ний өдрийн 01/339 дүгээр албан тоот бичгээр хүргүүлсэн.



Сүмбэр сумын ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар тус сумын гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө болон байгалийн дурсгалт түүхт газрын хаягийн зургийг батлуулсан.




Газар өмчлөл:

Алтадын гудамжинд шинээр газар өмчилсөн 5 иргэний материалыг тухайн эздэд нь хүлээлгэн өгсөн.

Сүмбэр сумын Тэрэгтийн гудамжинд 1008 иргэн, Өехийгийн гудамжинд 400 иргэн, Хувийн байрны 15 иргэн нийт 1423 иргэний шинээр газар өмчлөх шийдвэрийг гаргуулсан.

Барилга хот, байгуулалтын яамнаас зохион байгуулсан “Гэр хорооллын дахин төлөвлөлт”-ийн сургалтанд Барилгын хэлтсийн дарга Б.Даваажаргал, Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл хариуцсан мэргэжилтэн Д.Ганзориг нар оролцсон.

Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Орон зайн суурь мэдээллийн санг ашиглах нь” сэдэвт сургалтанд Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл хариуцсан мэргэжилтэн Д.Ганзориг оролцсон.



Барилга захиалагчийн хяналтын чиглэлээр:

1. 100 хүүхдийн канад загварын цэцэрлэгийн барилга угсралтын ажил
2. Баянбулгийн эгнээний тохижилтын ажил
3. Баянтал сум 152 дугаар байрны гадна тохижилт захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.

1. 100 хүүхдийн канад загварын цэцэрлэгийн барилга:


Төсвийн тодотголоор цэцэрлэгийн барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн тул гүйцэтгэгч "Хялганат нуга" ХХК нь барилгын эвдэрч гэмтсэн хаалга цонхыг шинээр хийж битүүмжилж гадна цахилгаан дотор монтаж гадна цэвэр бохирын шугамын ажлыг эхлүүлэхээр материал таталт, угсралтын ажлыг эхлүүлээд байна. 2017 оны 11 дүгээр сард Барилгын хөгжлийн төв, гүйцэтгэгч компани аймгийн ГХБХБГ-ын төлөөллүүд барилгын ажилтай танилцаж, өмнө нь гарч байсан дүгнэлт зөвлөмжийн дагуу ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй гэж үзлээ. Ажил гүйцэтгэхэд хүндрэлтэй ажил нь техникийн нөхцлүүдийн хугацаа дууссан байна.



2. Баянбулгийн эгнээг жишиг гудамж болгох ажил:

Ажлын гүйцэтгэл 2017 оны 11 дугаар сарын 20-ны байдлаар 90 гаруй хувьтай хийгдсэн байна. Техникийн комисс ажиллуулахаар гүйцэтгэгч “Чингисийн отог” ХХК-иас хүсэлт ирсэн байна.

3. Баянтал сум 152 дугаар байрны гадна тохижилт:



Ажлын гүйцэтгэл 2017 оны 11 дүгээр 20-ний байдлаар 90 гаруй хувьтай ажил хийгдсэн байна. Дутуу ажил сүүдрэвч ком тоглоом ирж суурилуулаагүй, ногоон байгууламжийн ажил хийгдээгүй байна.

Гүйцэтгэгч: “Койт трейд” ХХК Захиалагч Баянтал сумын ЗДТГ

Барилгын материалын чиглэлээр:

Барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “ОСО констракшн” ХХК-ийн үйлдвэрийн байранд 2017 оны 11 дүгээр 20-ний өдөр очиж хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр хяналт шалгалт явуулж үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР